

АРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2016 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2014 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 7/03

Цэцэрлэг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай Монгол Улсын хуулийн 13.5, 13.4.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний Аудитын газрын харьяа Архангай аймгийн Аудитын газрын 2017 оны төлөвлөгөө, Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний Аудитын Газар болон Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн аудит хариуцсан Ахлах аудитор /Н.Алтантуяа/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР





**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

**АРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ
ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас:70333141

Аудитын менежер:
Утас: 70332860

ТАБ-ын хаяг:
Архангай аймгийн Аудитын
газар

Байршил: Цэцэрлэг хот

Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

АГУУЛГА	Товчилсон үгийн жагсаалт	2
Тайланг бэлтгэсэн:	Нэг. Ерөнхий зүйл	
Архангай аймгийн Аудитын газар	1.1 Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	3
Дарга, тэргүүлэх аудитор:	1.2 Аудитын арга зүй.....	3
Д.Уламбаяр	1.3 ОНТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....	4
Аудитын менежер:	Хоёр. Санхүүгийн дотоод хяналт	5
Т.Байгалмаа	Гурав. Шилэн дансны мэдээлэл.....	6
Ахлах аудитор:	Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох.....	6
Н.Алтантуяа	Тав. Санхүүгийн тайлангийн дансдын талаар	6
Аудитор	5.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	6
П.Энхжаргал	5.1.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар	6
	5.1.2 Арилжааны банкин дахь харилцах дансдын талаар.....	8
	5.2. Авлагын бүртгэл, тайлагнал	9
	5.2.1 Авлагын бүтцийн талаар.....	10
	5.2.2 Авлагын үлдэгдэл, тооцоо нийлэлт.....	10
	5.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал	13
	5.3.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар ..	13
	5.3.2 Үнэ төлбөргүй авсан болон акталсан бараа материал.....	15
	5.3.3 Бусад эргэлтийн хөрөнгө	15
	5.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	16
	5.4.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....	16
	5.4.2 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл.....	19
	5.4.3 Үнэ төлбөргүй авсан болон акталсан үндсэн хөрөнгө.....	20
	5.5 Өр төлбөрийн бүртгэл тайлагнал	21
	5.5.1 Өр төлбөрийн бүтцийн талаар	21
	5.5.2 Өр төлбөрийн дансны үлдэгдэл тооцоо нийлэлт.....	23
	5.6 Орлого, татаас, санхүүжилт.....	25
	5.6.1 Төсвийн орлого.....	25
	5.6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт.....	25
	5.6.3 Өөрийн орлого.....	28
	5.6.4 Татварын орлого	28
	5.7 Зарлагын талаар	29
	5.7.1 Санхүүжилтийн зарцуулалт.....	29
	5.7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт.....	31
	5.7.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт.....	33
	5.7.4 Сангийн зарцуулалт.....	34
	5.8 Хуримтлагдсан үр дүнгийн талаар.....	35
	5.9 Эзэмшигчийн өмчийн талаар.....	36
	5.9.1 Орон нутгийн төсвийн эзэмшигчийн өмч.....	36
	5.10 Дахин үнэлгээний нөөцийн талаар.....	36
	5.11 Хөрөнгө оруулалтын талаар.....	36
	6.1 Тусгай зориулалтын шилжүүлгийн аудитын дүнгийн талаар.....	36
	7.1 Төсвийн шүүд захирагчдын аудитын дүнгийн талаар.....	37
	8.1 Сумдын төсвийн ерөнхийлөн захирагчдын аудитын дүнгийн ..талаар.....	37
	9.1 Орон нутгийн сан, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	38
2017 оны 4 дүгээр сар	10.1 ОНӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	38
	11.1 ОНТЕЗ-чид болон түүний харъяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.....	38
	12.1 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	39
	13.1 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл.....	41
	14.1 Уламжлах санал.....	40
	14.2 Хавсралт.....	42

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

Товчилсон үгийн жагсаалт	
АХБ	Азийн хөгжлийн банк
ААМ	Аж ахуйн материал
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
БТСГазар	Биеийн тамир спортын газар
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МӨОНС	Малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сан
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УХӨТ	Урт хугацаат өр төлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОСС	Орон сууцны сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЯ	Сангийн яам
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ХДТ	Хөгжимт драмын театр
ХАХНХС	Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайд
ХГБХХ	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
ӨХС	Өмч хувьчлалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭЭС	Эмийн эргэлтийн сан

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Архангай Аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

1.2 АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ

ОНТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн зөв шударга илэрхийлэгдсэн эсэх талаар дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

ОНТЕЗ-ийн санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Архангай аймгийн Аудитын газар ОНТЕЗ-ийн 2016 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу бүх шатны төсвийн захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- Сумдын ТЕЗ-ийн тайлан- 19
- Төсвийн шууд захирагчдын – 166
- төсөл сангийн -69 /ОНХСанг оруулсан/
- орон нутгийн өмчит үйлдвэрийн газар -4 нийт 258 санхүүгийн тайлан, орон нутгийн нөөц хөрөнгө, замын сан, мал эмнэлэгийн үйлчилгээ, албан журмын даатгал, чөлөөт ахмадын холбооны санхүүгийн дэмжлэг зэрэг зардлын дансдын гүйлгээ хамрагдсан байна.

1.3 АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитын аргачлал нь төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу бүх шатны төсвийн захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Дээрх тайлангуудыг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу Сангийн Яамны mof.gov.mn сайтад байрлах Э-тайлангаар нэгтгэн гаргажээ.

ХОЁР.САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ

Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагч 2016 онд санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол улсын Нягтлан бодох бүртгэл, Төсвийн тухай хууль болон Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого заавар, журмыг баримтлан ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 2.10-д заасан ТЕЗ нар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 69-р зүйлийн 69.1-д заасан ТЕЗ бүр дотоод аудитын алба байгуулж ажиллах тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

2015 онд Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2016 оны төлөвлөгөөний үйл ажиллагааны аудитын жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аудит хяналт шалгалтын ажлыг төлөвлөгөөт 81, төлөвлөгөөт бус 3 байгууллагад хийж, нийт 64 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид анхаарах асуудлаар хугацаатай зөвлөмж бэлтгэн харилцагч байгууллагын төсөв захирагч нарт хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллажээ.

Мөн 25 өргөдөл гомдол хүлээн авснаас ажилтан, албан хаагчидттай холбоотой асуудлыг бүрэн шийдвэрлэж, холбогдох байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтуудыг хийж, санал гомдлыг барагдуулан ажилласан байна.

Сумдын санхүүгийн алба, төсвийн шууд захирагчид, боловсрол, соёлын салбарын удирдах ажилтнууд, нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг тодорхой хөтөлбөр, сэдвийн хүрээнд аймгийн ЗДТГ болон БСУГ-тай хамтран зохион байгуулжээ.

ГУРАВ:ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, ОН-ийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллахаар заасан.

ОНТЕЗ-ийн харъяа байгууллагууд хуулинд заасан дээрх мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулж байгаа бөгөөд хэрэгжилтэд аймгийн Аудитын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хяналт тавьж, албан шаардлага, зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

ДӨРӨВ: МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

Материаллаг байдлын түвшинг 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1,094.4 сая төгрөгөөр буюу санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлогын 1 хувиар тооцсон дүнг сонгон авлаа.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлогын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь тухайн байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

ТАВ: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДАНСДЫН ТАЛААР

5.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.1.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮТЦИЙН ТАЛААР:

ОНТЕЗ -ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сангийн дансны үлдэгдэл
- Арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан
- Төсөл сангийн харилцах дансдын үлдэгдэл
- ОНӨҮГ-уудын арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл
- ОНӨҮГ-ын кассад байгаа бэлэн мөнгө

ОНТЕЗ -ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос **1.6** дахин өсч **6,013.8** сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний **91.2** хувь буюу **5,487.8** сая төгрөг төрийн санд, **8.6** хувь буюу **521.8** сая төгрөг нь арилжааны банкинд, **0.06** хувь буюу **4.2** сая төгрөг нь кассад байна.

ОНТЕЗ-ийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/ мянган төгрөгөөр/					
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Төрийн сан	Арилжааны банк
Кассад байгаа бэлэн мөнгө:	9,799.55	4,161.93	4,161.93		
Төгрөг/ЖМС	9,799.55	4,161.93	4,161.93		
Банкинд байгаа бэлэн мөнгө:	3,858,825.62	6,009,693.57	-	5,487,861.66	521,831.90
Төрийн сангийн харилцах	2,424,905.57	5,487,861.66		5,487,861.66	
Арилжааны банкны харилцах	434,829.80	521,831.91			521,831.90
Бусад төсөл нөөцийн харилцах	999,090.25	-			
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	3,868,625.17	6,013,855.50	4,161.93	5,487,861.66	521,831.90
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:					
Төсвийн байгууллага	352,131.57	664,487.46	5.07	625,940.55	38,541.84

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

Төрийн сан	2,010,652.82	2,933,163.41		2,933,142.11	21.30
Төсөл сан	1,139,234.01	1,928,779.00		1,928,779.00	
ОНӨҮГазар	366,606.77	487,425.63	4,156.86		483,268.77
нийт мөнгөн хөрөнгийн дүн	3,868,625.17	6,013,855.50	4,161.93	5,487,861.66	521,831.91

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн нийт үлдэгдлийн 11.1 хувь нь төсөвт байгууллагын, 48.7 хувь нь төрийн сангийн үлдэгдэл буюу орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлого, 32.1 хувь нь төсөл сангийн, 8.1 хувь нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тус тус байна.

- Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 664.5 сая төгрөгийн 15.8 хувь буюу 38.5 сая төгрөг нь халамжийн сангийн арилжааны банкин дахь олгогдоогүй тэтгэмжийн, 73.6 хувь буюу 625.9 сая төгрөг ОНХСангийн зарцуулагдаагүй үлдэгдэлүүд тус тус байна.
- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,933.2 сая төгрөгийн 1,607.3 сая төгрөг нь сумдын давсан орлого, 1,325.9 сая төгрөг нь аймгийн давсан орлого болон төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Сумдын нэр	Төрийн сангийн үлдэгдэл
1	Эрдэнэбулган	126,714.4
2	Чулуут	4,981.6
3	Хайрхан	1,713.8
4	Хотонт сум	267,319.0
5	Цэнхэр сум	464,098.6
6	Өндөр-Улаан сум	4,498.7
7	Төвшрүүлэх сум	7,301.5
8	Батцэнгэл сум	2,278.5
9	Өлзийт сум	279.1
10	Өгийннуур сум	616.8
11	Эрдэнэмандал сум	28,618.2
12	Цэцэрлэг сум	2,508.1
13	Жаргалант сум	267,832.8
14	Тариат сум	50,766.4
15	Хангай сум	12,957.0
16	Цахир сум	9,373.6
17	Булган сум	54,931.8
18	Ихтамир сум	294,697.0
19	Хашаат сум	5,816.2
20	Аймгийн Төрийн сан	1,325,860.2

		2,933,163.4
--	--	-------------

- Аймгийн төрийн сан дахь 1,325.9 сая төгрөгийн үлдэгдэлийн 800.0 сая төгрөг халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл, 65.2 сая төгрөг нь СЯ-наас өвөлжилтийн нөхцөл байдалтай холбоотой ирсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, 113.6 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын хэмнэлтээр төвлөрүүлсэн үлдэгдэл, 347.1 сая төгрөг аймгийн орон нутгийн давсан орлого тус тус байна.
- Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,928.8 сая төгрөгийн 709.2 сая төгрөг нь СХС-ийн, 64.4 сая төгрөг нь аймгийн МХС-ийн, 12.3 сая төгрөг нь аймгийн ОНХС-ийн, 185.9 сая төгрөг нь татан төвлөрүүлэлтийн дансны, 957.0 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлүүд тус тус байна.
- ОНӨҮГазрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 487.4 сая төгрөгийн үлдэгдэл байгаагийн 487.0 сая төгрөг нь Ундарга ОНӨХХК-ний үлдэгдэл, 0.4 сая төгрөг нь Өндөр-Улаан сумын ЭЭС-ийн үлдэгдэл тус тус байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулбал төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 312.4 сая төгрөгөөр, төрийн сангийн үлдэгдэл 922.5 сая төгрөгөөр, төсөл сангийн үлдэгдэл 789.6 сая төгрөгөөр, ОНӨҮГ-ын үлдэгдэл 120.8 сая төгрөгөөр нийт 2,145.2 сая төгрөгөөр өссөн байна.

5.1.2 АРИЛЖААНЫ БАНКИН ДАХЬ ХАРИЛЦАХ ДАНСДЫН ТАЛААР:

Арилжааны банкинд байршиж буй мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 7.3 хувь буюу 38.5 сая төгрөг нь халамжийн сангийн олгогдоогүй тэтгэмж, 0.02 хувь буюу 0.1 сая төгрөг нь төсөвт байгууллага, орон нутгийн орлогын дансны үлдэгдэл, 92.6 хувь буюу 483.2 сая төгрөг нь ОНӨҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Арилжааны банкны үлдэгдлийг зориулалтаар нь хүснэгтээр харуулбал:

Сумын нэр	Үлдэгдэл			НИЙТ ҮЛДЭГДЭЛ	Дансны тоо
	ОНЕО	Харилцах данс	Хугацаатай хадгалмж		
Төвшрүүлэх сум	10.0			10.0	1
Батцэнгэл сум	11.0			11.0	2
Хашаат сум	0.3			0.3	1
Ихтамир ойн анги		4.0		4.0	1
Хотонт сумын хүүхдийн цэцэрлэг		26.3		26.3	1
СТССургууль		20.31		20.31	1
Хашаат сумын ЕБС		3.5		3.5	
Халамжийн сан		38,487.73		38,487.73	7
Ундарга ОНӨХХК		282,844.80	200,000.0	482,844.80	5

Өндөр-Улаан сум ЭЭС		423.97		423.97	1
НИЙТ ДҮН	21.3	321,810.61	200,000.0	521,831.91	20

5.2 АВЛАГЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.2.1 АВЛАГЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР:

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл **7,521.1** сая төгрөг байснаас тайлант онд **357.1** сая төгрөгөөр буурч, оны эцэст **7,163.7** төгрөгөөр тайлагнагдсан байна. Нийт авлагын 0.08 хувь ажилчидтай холбоотой авлага, 98.6 хувь нь хувь хүнээс авах авлага, 0.15 хувь нь төлбөртэй үйлчилгээний авлага, 1.15 хувь нь байгууллагаас авах авлага тус тус эзэлж байна.

Авлагын бүтцийг авч үзвэл ажилчидтай холбоотой авлага **10.8** сая төгрөгөөр, хувь хүнээс авах авлага **134.4** сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага **220.0** сая төгрөгөөр тус тус буурсан бөгөөд харин төлбөртэй үйлчилгээний авлага өмнөх оноос **8.2** сая төгрөгөөр өссөн байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагаар нь харуулбал:

/Мянган төгрөгөөр/

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Ажилчидтай холбоотой авлага	16,577.48	5,732.05	(10,845.43)
Хувь хүнээс авах авлага	7,198,993.08	7,064,566.97	(134,426.11)
Төлбөртэй үйлчилгээний авлага	2,547.95	10,723.29	8,175.34
Байгууллагаас авах авлага	302,985.54	82,949.81	(220,035.73)
Нийт дүн	7,521,104.05	7,163,972.12	(357,131.93)
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	91,357.50	46,097.30	(45,260.20)
Төрийн сан	46,303.15	46,386.23	83.08
Төсөл сан	7,193,465.95	7,049,067.02	(144,398.93)
ОНӨҮГазар	189,977.46	22,421.57	(167,555.89)
Нийт дүн	7,521,104.05	7,163,972.12	(357,131.93)

Нийт авлагын 0.6 хувь нь төсөвт байгууллагын, 0.6 хувь нь төрийн сангийн, 98.4 хувь нь төсөл сангийн, 0.3 хувь нь ОНӨҮГ-ын авлага байна.

Авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Архангай аймаг шууд	326,041.23	99,968.26	(226,072.97)
2	Батцэнгэл	323,939.19	308,061.79	(15,877.40)

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

3	Булган	275,110.60	267,246.25	(7,864.35)
4	Жаргалант	366,890.29	299,985.35	(66,904.94)
5	Ихтамир	413,620.02	404,949.28	(8,670.74)
6	Тариат	357,709.16	392,452.56	34,743.40
7	Төвшрүүлэх	345,478.44	352,443.16	6,964.72
8	Хайрхан	353,945.20	351,188.99	(2,756.21)
9	Хангай	279,465.08	308,976.28	29,511.20
10	Хашаат	326,728.53	355,912.25	29,183.72
11	Хотонт	369,935.01	379,626.99	9,691.98
12	Цахир	228,093.92	173,215.52	(54,878.40)
13	Цэнхэр	332,665.36	374,593.24	41,927.88
14	Цэцэрлэг	295,727.83	325,858.00	30,130.17
15	Чулуут	304,975.98	315,102.43	10,126.45
16	Эрдэнэбулган	1,220,037.64	1,215,822.06	(4,215.58)
17	Эрдэнэмандал	400,697.76	318,637.47	(82,060.29)
18	Өгийнуур	291,663.37	220,598.59	(71,064.78)
19	Өлзийт	298,441.32	275,719.18	(22,722.14)
20	Өндөр-Улаан	409,938.12	423,614.47	13,676.35
	Нийт	7,521,104.05	7,163,972.12	(357,131.93)

5.2.2 АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, ТООЦОО НИЙЛЭЛТ

Төсөвт байгууллагын авлагыг тодруулбал:

Төсөвт байгууллагын авлага 46.1 сая төгрөгөөр тайлагнагдсаны 41.2 хувь буюу 19.0 сая төгрөг нь орон нутгийн байгууллагын, 53.6 хувь буюу 24.7 сая төгрөг нь боловсрол, соёлын салбарын, 5.2 хувь буюу 2.4 сая төгрөг нь эрүүл мэндийн салбарын байгууллагуудын авлага байна.

Төсвийн шууд захирагчид авлагатай ажиллаж байгаа нь “Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйг харуулж байна. Аудитаас төсөв захирагч бүрд авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажилласан болно.

Төсөл сангийн авлагыг тодруулбал:

Төсөл сангийн авлага нь төсөл сангийн шугамаар иргэдэд олгож байгаа зээлийн эргэн төлөлт мөн эргэн төлөгдөх нөхцлөөр жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зорилгоор СХС-аас олгосон зээлтэй холбоотой үүссэн бөгөөд авлагын дүн өмнөх оноос **144.4** сая төгрөгөөр буурсан байна.

Төсөл сангийн авлагын 99.0% буюу 7,011.1 сая төгрөгийг сум хөгжүүлэх сан, 0.5% буюу 33.9 сая төгрөгийг Эрдэнэбулган сумын МӨОНСан, 0.05% буюу 4.1 сая төгрөгийг аймгийн мал хамгаалах сан эзэлж байна. Үүнээс:

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

Сум хөгжүүлэх сангийн авлагыг сумдаар харуулбал:

/ мянган төгрөгөөр/

№	Сумдын нэр	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	зөрүү
1	Эрдэнэбулган	1,185,522.83	1,181,951.24	-3,571.59
2	Өндөр улаан	409,938.12	423,614.47	13,676.35
3	Их тамир	399,984.28	404,949.28	4,965.00
4	Чулуут	294,912.02	314,956.35	20,044.33
5	Хангай	270,852.06	307,549.45	36,697.39
6	Тариат	344,414.17	391,042.56	46,628.39
7	Эрдэнэмандал	388,697.76	318,637.47	-70,060.29
8	Жаргалант	366,713.18	299,985.35	-66,727.83
9	Цэцэрлэг	295,727.83	325,858.00	30,130.17
10	Хайрхан	338,168.76	347,278.84	9,110.08
11	Батцэнгэл	312,827.59	304,175.19	-8,652.40
12	Өлзийт	288,417.00	275,219.18	-13,197.82
13	Өгийнуур	268,051.64	220,598.59	-47,453.05
14	Хашаат	323,125.99	352,309.72	29,183.73
15	Хотонт	362,198.87	375,837.10	13,638.23
16	Цэнхэр	332,638.30	374,593.24	41,954.94
17	Төвшрүүлэх	339,471.96	352,443.16	12,971.20
18	Булган	275,032.35	267,099.65	-7,932.70
19	Цахир	217,652.08	172,985.52	-44,666.56
	ДҮН	7,014,346.78	7,011,084.35	-3,262.43

ОНТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсөл сангийн авлагын судалгаанаас үзэхэд холбогдох албан тушаалтнууд авлагын тооцоог тухай бүр хийж барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авахгүй, санал санаачлага гаргахгүй байгаагаас авлага он дамжин хадгалагдаж, насжилт нэмэгдэн улмаар төлөгдөх найдваргүй болох нөхцөл байдал үүсч болзошгүй болсон байна.

Иймд аудитаас бүх сумдад СХС-ийн орлогын төлөвлөгөөний биелэлт, зээлийн эргэн төлөлтөнд анхаарч, тодорхой арга хэмжээг цаг алдалгүй авах талаар зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Төрийн сангийн авлагыг тодруулбал:

Төрийн сангийн авлага нийт **46.3** сая төгрөг байгаагаас **39.8** сая төгрөг нь 2001 онд үүссэн 15 жилийн насжилттай өвс тэжээлийн авлага, **6.5** сая төгрөг нь Атрын 3-р аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон зээлийн авлага байгаа бөгөөд хоорондын тооцоо нийлсэн актгүй байна.

Эдгээр авлагыг барагдуулах талаар өмнөх жилүүдийн аудитаар зөвлөмж хүргүүлж байсан ч зөвлөмжийн мөрөөр тодорхой үр дүнтэй арга хэмжээ авдаггүй,

анхаардаггүй байсаар өнөөг хүргэсэн бөгөөд энэ жилийн тайланд мөн барагдаагүй, ямар байгууллага, хувь хүнээс авах нь тодорхойгүй байдал хэвээр байсаар байна.

Энэ талаар ҮАГ-аар дамжуулан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан мэдэгдэх болно.

ОНӨҮГ-ын авлагыг тодруулбал:

ОНӨҮГ-ын авлага өмнөх онд 189.4 сая төгрөг байсан бол энэ онд 22.4 сая төгрөг болж 189.0 сая төгрөгөөр буурсан байна.

5.3 БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.3.1. БАРАА МАТЕРИАЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР :

ОНТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын үлдэгдэл **4,681.1** сая төгрөгөөр тайлагнагдсан нь өмнөх оноос **230.2** сая төгрөгөөр өссөн байна.

/Мянган төгрөгөөр/

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Тусгай зориулалтын материал	417,105.22	526,531.69	109,426.47
Эм боох материал	82,818.72	89,425.53	6,606.81
Дуусаагүй үйлдвэрлэл	188.40	69,501.10	69,312.70
Бэлэн бүтээгдэхүүн	1,907.70	410.05	(1,497.65)
Бичиг хэргийн материал	200,464.01	147,826.20	(52,637.81)
Аж ахуйн материал	2,702,704.29	2,883,857.06	181,152.77
Сэлбэг хэрэгсэл	140,103.50	155,315.86	15,212.36
Түлш, шатах тослох материал	195,823.87	196,548.10	724.23
Барилга засварын материал	120,320.90	115,862.67	(4,458.23)
Хүнсний материал	111,516.94	76,041.53	(35,475.41)
Бусад хангамжийн материал	84,904.12	100,673.13	15,769.01
Мал амьтад	261,035.73	241,295.38	(19,740.35)
Нөөцийн бараа	131,911.53	77,780.35	(54,131.18)
НИЙТ ДҮН	4,450,804.92	4,681,068.65	230,263.73
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	4,189,847.36	4,459,364.49	269,517.13
Төрийн сан	-	-	-
Төсөл сан	93,392.87	37,238.50	(56,154.37)
ОНӨҮГазар	167,564.69	184,465.66	16,900.97
Нийт дүн	4,450,804.92	4,681,068.65	230,263.73

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6,873.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд хандив тусламжаар 116.7 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээр 270.8 сая төгрөгийн, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 66.3 сая төгрөгийн бараа

материалыг шилжүүлэн авч, тайлант онд 7,096.9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 230.2 сая төгрөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 95.2 хувь буюу 4,459.3 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 0.8 хувь буюу 37.2 сая төгрөг нь төсөл сангийн, 3.9 хувь буюу 184.4 сая төгрөг нь ОНӨҮГ-ын бараа материал тус тус эзэлж байна.

Үүнээс бараа материалын төрлөөр харуулцал:

Тусгай зориулалтын материал өмнөх оноос 109.4 сая төгрөгөөр, эм боох материал 6.6 сая төгрөгөөр, дуусаагүй үйлдвэрлэл 69.3 сая төгрөгөөр, ААМ 181.1 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 15.2 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 15.7 сая төгрөгөөр, түлш шатах тослох материал 0.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Харин бэлэн бүтээгдэхүүн өмнөх оноос 1.5 сая төгрөгөөр, бичиг хэргийн материал 52.6 сая төгрөгөөр, барилгын засварын материал 4.4 сая төгрөгөөр, хүнсний материал 35.5 сая төгрөгөөр, нөөцийн бараа 54.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Мал амьтад нь төсвийн байгууллагын бараа материалын бүрэлдэхүүнд орж байгаа бөгөөд өмнөх оноос 7.5 хувиар буюу 19.7 сая төгрөгөөр буурчээ.

5.3.2 ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АВСАН БОЛОН АКТАЛСАН БАРАА МАТЕРИАЛ

Тайлант хугацаанд 116.7 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хандиваар авсан ба үүний 14.3 хувь буюу 16.7 сая төгрөг нь тусгай зориулалтын материал, 3.2 хувь буюу 3.8 сая төгрөг нь бичиг хэргийн материал, 0.6 хувь буюу 0.8 сая төгрөг нь эм боох материал, 63.8 хувь буюу 74.4 сая төгрөг нь аж ахуйн материал, 14.0 хувь буюу 16.7 сая төгрөг нь түлш шатах тослох материал, 2.7 хувь буюу 3.2 сая төгрөг нь хүнсний материал, 1.3 хувь буюу 1.5 сая төгрөгийн мал амьтад тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд **92.6** сая төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

5.3.3 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Тайлант онд бусад эргэлтийн хөрөнгө дансанд нийт **441.4** сая төгрөгийг бүртгэсэн бөгөөд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа их засвар хөрөнгө оруулалтын бүрэн дуусч хүлээн аваагүй байгаа ажлуудыг бүртгэж тайлагнасан байна.

Үүнд: нэгдсэн эмнэлэгийн дээврийн их засвар, нийтийн номын сангийн барилгын ажил, Эрдэнэбулган сумын барилгын багийн төвийн барилга, Төвшрүүлэх болон Чулуут сумын ЗДТГ-уудын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлууд байна.

Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой Төсвийн шууд захирагчдын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлын талаар:

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, бараа материалын хөдөлгөөний тайлан гаргаагүй, үдийн цайны норм нормативыг мөрдөөгүйгээс хоолны зардлыг илүү болон дутуу бодож олгосон, мөн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хүнсний үлдэгдлийг их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөнтэй холбоотой нийт **719.3** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Үүнд: Бараа материалын тайлан зөрүүтэй гаргасан 130.7 сая төгрөгийн, нэр төрлөөр данс бүртгэлд тусгаагүй бөөн дүнгээр орлогод авсан 24.8 сая төгрөгийн, тендер зарлаад сонгогдсон иргэн, аж ахуйн нэгжээс худалдан авалт хийгээгүй 175.7 сая төгрөгийн, үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоолны норм нормативыг тооцоогүй 4.1 сая төгрөгийн, хүнсний материал болон тээвэр шатахууны зардлын үлдэгдлийг төвлөрүүлээгүй 48.3 сая төгрөгийн, Худалдан авалт, тендертэй холбоотой 185.8 сая төгрөгийн, тээвэр шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт алдагдсан буюу жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, норм болон хэтрэлт хэмнэлтийг тооцоогүйтэй холбоотой 149.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажилласан.

5.4 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.4.1 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААР

ОНТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө **120,134.8** сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд өмнөх оноос **0.9** хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгийн ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Барилга, байгууламж, орон сууц	78,641,403.20	79,256,580.25	615,177.05
Авто тээврийн хэрэгсэл	3,301,513.43	3,110,554.02	(190,959.41)
Машин тоног төхөөрөмж	12,311,582.88	12,232,299.22	(79,283.66)
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,189,840.84	3,131,312.90	(58,527.94)
Зам, гүүрийн байгууламж	397,795.17	297,379.41	(100,415.76)
Түүх, соёл музейн дурсгалт зүйлс	1,039,134.87	1,276,449.10	237,314.24
Бусад үндсэн хөрөнгө	9,590,359.92	8,841,070.58	(749,289.34)
Номын фонд	910,163.93	960,126.69	49,962.76

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*


Дуусаагүй барилга,байгууламж	11,750,499.40	10,977,268.36	(773,231.04)
Биет бус хөрөнгө	54,605.88	51,765.09	(2,840.79)
Нийт дүн	121,186,899.52	120,134,805.62	(1,052,093.90)
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	115,436,105.09	114,459,409.51	(976,695.58)
Төрийн сан	-	-	-
Төсөл сан	108,797.83	185,897.17	77,099.34
ОНӨҮГазар	5,641,996.60	5,489,498.94	(152,497.66)
Нийт дүн	121,186,899.52	120,134,805.62	(1,052,093.90)

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 99.96 хувийг биет хөрөнгө, 0.04 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Өмнөх оноос барилга байгууламж 0.8 хувь буюу 615.2 сая төгрөгөөр, түүх соёлын дурсгалт зүйл 22.8 хувь буюу 237.3 сая төгрөгөөр, номын фонд 5.4 хувиар буюу 49.9 сая төгрөгөөр тус тус өссөн бол авто тээврийн хэрэгсэл 5.8 хувь буюу 190.9 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж 0.6 хувь буюу 79.3 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 1.8 хувь буюу 58.5 сая төгрөгөөр, зам гүүрийн байгууламж 25.2 хувь буюу 100.4 сая төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 7.8 хувь буюу 749.3 сая төгрөгөөр, дуусаагүй барилга, байгууламж 6.6 хувь буюу 773.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн 95.2 хувь нь төсвийн байгууллагын, 4.6 хувь нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн, 0.2 хувь нь төсөл сангийн үндсэн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгийг төрлөөр нь харуулбал:



Нийт үндсэн хөрөнгийн 66 хувийг барилга байгууламж, 10 хувийг машин тоног төхөөрөмж, 9 хувийг дуусаагүй барилга байгууламж, 7 хувийг бусад үндсэн хөрөнгө, 3 хувийг авто тээврийн хэрэгсэл, 3 хувийг тавилга эд хогшил, 1 хувийг түүх соёлын дурсалт зүйл, 1 хувийг номын фонд тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 14,453.7 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний дотор төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,037.3 сая төгрөг, хандив тусламжаар 1,745.3 сая төгрөг, шилжүүлж авсан 423.0 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр 7,371.0 сая төгрөг / орон нутгийн өмчийн алба, ХААА нэгдэж орон нутгийн өмчийн газар болсонтой холбоотой/, бусад 3,877.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Харин үндсэн хөрөнгө 10,931.4 сая төгрөгөөр хасагдсаны дотор акталж устгасан 2,388.4 сая төгрөг, шилжүүлсэн 1,018.9 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 7,524.1 сая төгрөг тус тус байна.

5.4.2 ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст **62,240.9** сая төгрөг байснаас тайлант хугацаанд **6,757.4** сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, өмнөх оны элэгдлийн зөрүү **385.2** сая төгрөгөөр хасагдаж, **1,797.8** сая төгрөгийг данснаас хасч тайлант онд **66,815.3** сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Үүнээс:

- ✚ Барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст 48,415.1 сая төгрөг байснаас тайлант онд 2,620.7 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 755.6 сая төгрөгийг данснаас хасч 50,280.2 сая төгрөгөөр
- ✚ Тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст 2,386.4 сая төгрөг байснаас тайлант онд 534.1 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 222.0 сая төгрөгийг данснаас хасч 2,698.5 сая төгрөгөөр
- ✚ Машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст 5,374.5 сая төгрөг байснаас тайлант онд 1,490.9 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 393.2 сая төгрөгийг данснаас хасч 6,472.2 сая төгрөгөөр
- ✚ Тавилга эд хогшлын хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст 2,749.6 сая төгрөг байснаас тайлант онд 631.6 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 156.8 сая төгрөгийг данснаас хасч 3,224.4 сая төгрөгөөр
- ✚ Зам гүүрийн байгууламжийн хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст 371.6 сая төгрөг байснаас тайлант онд 126.4 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 135.5 сая төгрөгийг данснаас хасч 297.4 сая төгрөгөөр
- ✚ Бусад үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст 2,914.6 сая төгрөг байснаас тайлант онд 939.0 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 404.7 сая төгрөгийг данснаас хасч 3,448.9 сая төгрөгөөр
- ✚ Биет бус хөрөнгө хуримтлагдсан элэгдэл 2015 оны эцэст 29.0 сая төгрөг байснаас тайлант онд 29.4 сая төгрөгийн элэгдэл байгуулагдаж, 1.0 сая төгрөгийг данснаас хасч 57.4 сая төгрөгөөр тус тус тайлагнасан байна.

5.4.3 ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АВСАН БОЛОН АКТАЛСАН ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Тайлант хугацаанд 1,745.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр болон хандиваар авч бүртгэл тайланд тусгасны 41.3 хувь буюу 721.5 сая төгрөг нь барилга байгууламж, 13.1 хувь буюу 228.1 сая төгрөг нь тээврийн хэрэгсэл, 18.5 хувь буюу 322.0 сая төгрөг нь машин тоног төхөөрөмж, 18.2 хувь буюу 319.2 сая төгрөг нь тавилга эд хогшил, 0.5 хувь буюу 7.9 сая төгрөг нь түүх соёлын дурсгалт зүйл, 1.2 хувь буюу 20.4 сая төгрөг нь номын фонд, 7.2 хувь буюу 126.3 сая төгрөг нь бусад үндсэн хөрөнгө байна.

Мөн тайлант хугацаанд 3,877.1 төгрөгийг бусад гэсэн ангилалаар орлого авч /УТХО болон ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд/ бүртгэл тайланд тусгасан байна.

Тайлант хугацаанд өмчийн албаны зөвшөөрлөөр 2,388.4 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой Төсвийн шууд захирагчдын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлын талаар:

Төсвийн шууд захирагчдын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн худалдан авалт, бүртгэл тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.Үүнд:

- Үндсэн хөрөнгө бэлтгэхдээ Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл аваагүй:- Жаргалант, Хайрхан, Чулуут, Цахир, Цэцэрлэг сумдын ЗДТГ, Цэцэрлэг сумын ахлах сургууль, Өлзийт хүүхдийн цэцэрлэг, Өлзийт сумын ЭМТ-үүдийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн **14.2.4-д “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн хороонд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах”** гэсэн заалтыг зөрчсөн 72.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд аудитаас зөрчил арилгуулах тухай албан шаардлагыг хүргүүлээ.
- Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн **13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”** гэсэн заалтыг зөрчиж үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй 38.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүлээ.

5.5 ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

5.5.1 ӨР ТӨЛБӨРИЙН БҮТЦИЙН ТАЛААР

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

ОНТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл **6,646.4** сая төгрөг байснаас тайлангийн эцэст **6,208.9** сая төгрөг болж **437.5** сая төгрөгөөр буурсан байна.

Нийт өр төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/мянган

төгрөгөөр/

Өр төлбөрийн ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Богино хугацаат өр төлбөр	4,417,427.87	3,979,938.88	(437,489.00)
Ажилчидтай холбоотой өглөг	57,545.27	15,493.22	(42,052.05)
Урьдчилж орсон орлого	1,086.40	2,003.61	917.21
Бараа үйлчилгээний зардлын өглөг	225,501.92	907.98	(224,593.94)
Байгууллагад төлөх өглөг	278,156.19	219,453.90	(58,702.29)
Хувь хүмүүст төлөх өглөг	118,391.52	116,607.87	(1,783.65)
Татварын өр	15,744.98	2,861.73	(12,883.25)
НДШ-ийн өр	-	64.80	64.80
Ноогдол ашгийн өр	2,211.58	3,406.84	1,195.25
Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг / БХӨТ-т тайлагнагдсан/	3,718,790.01	3,619,138.93	(99,651.08)
Урт хугацаат өр төлбөр	2,229,007.29	2,229,007.29	(99,651.08)
ОНӨААН-үүдийн зээлийн өглөг	2,229,007.29	2,229,007.29	-
Нийт дүн	6,646,435.17	6,208,946.17	(437,489.00)
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:			
Төсвийн байгууллага	584,765.71	162,718.06	(422,047.65)
Төрийн сан	0	1,742.14	1,742.14
Төсөл сан	10,583.78	187,220.81	176,637.04
ОНӨҮГазар	6,051,085.68	5,857,265.16	(193,820.52)
Нийт дүн	6,646,435.17	6,208,946.17	(437,489.00)

Нийт өр төлбөрийн 64.1 хувь нь богино хугацаат өр төлбөр, 35.9 хувь нь урт хугацаат өр төлбөр байна.

Нийт өр төлбөрийг байгууллагаар авч үзвэл 2.63 хувийг төсөвт байгууллагын, 3.01 хувийг төсөл сангийн, 0.02 хувийг төрийн сангийн, 94.34 хувийг ОНӨҮГ-ын өр төлбөр эзэлжээ.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 437.5 сая төгрөгөөр буурсан, харин УХӨТ өөрчлөлтгүй байна.

БХӨТ-ийн 91 хувь нь хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг, 6 хувь нь байгууллагад төлөх өглөг, 3 хувь нь хувь хүмүүст төлөх өглөг тус тус эзэлж байна.



5.5.2 ӨР ТӨЛБӨРИЙН ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ БАТАЛГААЖУУЛАЛТ, ТООЦОО НИЙЛЭЛТ

Төсөвт байгууллагын өр төлбөрийг тодруулбал:

Төсвийн байгууллагуудын өглөгийн 79.8 хувь 129.9 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын өр /үүнд халамжийн олгогдоогүй тэтгэмжийн өр 105.8 сая төгрөг, сумдын ЗДТГ, ИТХ-ын өр 24.1 сая төгрөг/, 17.9 хувь буюу 29.1 сая төгрөг нь БС-ын байгууллагын, 2.2 хувь буюу 3.6 сая төгрөг нь ЭМС-ийн байгууллагын, 0.03 хувь буюу 0.06 сая төгрөг нь БХБ-ын салбарын өр байна.

Төсөл сангийн өр төлбөрийг тодруулбал:

Төсөл сангийн өр төлбөрийн 187.2 сая төгрөг байгаагийн 1.0 сая төгрөг нь Төвшрүүлэх сумын СХС-ийн, 0.4 сая төгрөг нь Хашаат сумын СХС-ийн, 185.8 сая төгрөг аймгийн татан төвлөрүүлэлтийн дансны өр байна. Татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрсөн 185.8 сая төгрөгийг төсөвт байгууллагуудад буцаан олгох учраас өглөгөөр тусгаж тайлагнасан байна.


Αὐτὰρ ἀὐτὰρ	2,128,286.0	3,120,323.2	992,037.2	146.6
ὁρῶν ἰ οὐ αὐτὸς ὁρῶν αἰ	220,000.0	227,907.1	7,907.1	103.6
ἄρδῶν ἰ ὁ εἰ ὁ:	67,000.0	144,900.9	77,900.9	216.3
-----ἄρδῶν ἰ ὁ εἰ ὁ	32,000.0	48,713.9	16,713.9	152.2
-----Газрын дуудлага худалдааны орлого	35,000.0	96,187.0	61,187.0	274.8
ὁρῶν ἰ οὐ αὐτὸς ὁρῶν αἰ	45,000.0	24,546.8	-20,453.2	54.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	105,000.0	118,886.8	13,886.8	113.2
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	1,691,286.0	2,604,081.6	912,795.6	154.0
.....Байгалийн ургамал ашигласны төлбөр	965,614.8	1,892,175.6	926,560.8	196.0
----- ус, рашааны нөөц ашигласны төлбөр	323,435.3	376,057.3	52,622.0	116.3
-----ойн нөөц ашигласны төлбөр	383,932.0	319,718.8	-64,213.2	83.3
-----ан амьтаны нөөц ашигласны төлбөр	18,303.9	16,129.9	-2,174.0	88.1
5.Ὁ Αὐτὸς ἰ ὁ εἰ ἰ	505,821.0	727,582.2	221,761.2	143.8
ὁρῶν αἰ ἰ ἰ αἰ εἰ αἰ	2,711.0	4,211.5	1,500.5	
ὁρῶν αἰ ἰ αἰ αἰ	0.0	0.0	0.0	
ὁ ἰ αἰ αἰ αἰ ἰ αἰ αἰ	73,110.0	73,878.0	768.0	101.1
ὁ ἰ αἰ αἰ αἰ ἰ αἰ αἰ	210,000.0	372,640.8	162,640.8	177.4
ἰ ἰ αἰ αἰ αἰ αἰ αἰ αἰ	220,000.0	276,851.9	56,851.9	125.8
ὁ ἰ αἰ αἰ αἰ ἰ αἰ αἰ	37,000.0	42,703.5	5,703.5	115.4
ὁ ἰ αἰ αἰ αἰ αἰ αἰ αἰ	37,000.0	42,703.5	5,703.5	
ὁ ἰ αἰ αἰ αἰ αἰ αἰ αἰ	0.0	0.0	0.0	

- Ёнгийн үйлдвэрийг өргөсний дүнд 91.3 % орлогыг **8,090.4** сая төгрөгөөр дахин сэргээхэд нь, 8.2 % орлогыг **727.6 сая** төгрөгөөр баарцаагүй ажилтай байгаагаас, 0.5 % орлогыг **42.7 сая** төгрөгөөр бусад зориулалтаар зарцуулав.
- Ёнгийн үйлдвэрийг өргөсний дүнд барааны хөрөнгийг нэмэгдүүлэхийн тулд өөрсдийн эзлэхүүнтэй ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор үүссэн буруутгалын хэрэг бүртгэлээр үзвэл ханган биелүүлээгүй байна.
- 2016 онд 16 нэр төрлийн орлого **1,556.7** сая төгрөгөөр давж биелсэн бол, 4 нэр төрлийн орлого **106.8** сая төгрөгөөр тасарсан дүнтэй байна. Орлогын төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудыг нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

5.6.3 ТАТВАРЫН ОРЛОГО

Татварын орлогоор нь 2016 онд аймгийн төсөвт **6,868.0** сая төгрөг төвлөрүүлэхээс **8,090.4** сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг **1,222.4** сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.


Татварын орлогыг нэр төрлөөр нь графикаар харуулбал



Графикаас харахад татварын орлогын ихэнх буюу 50.3 %-г цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар эзэлж байна.

5.6.4 ТАТВАРЫН БУС БОЛОН ХӨРӨНГИЙН ОРЛОГО.

Татварын бус болон хөрөнгийн орлогоор аймгийн төсөвт **505.8** сая төгрөг төвлөрүүлэхээс **727.6** сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг **221.8** сая төгрөгөөр давуулжээ.



**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Татварын орлого нийт дүнгээр 1,222.4 сая төгрөгөөр давж биелэсэн хэдий ч 4 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

2016 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ДАВСАН ОРЛОГУУД					
№	ᠰᠡᠭᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ			
		ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар	4,477,325.7	4,481,842.9	4,517.2	100.1
2	Үйл ажиллагааны орлого	561,000.0	669,160.6	108,160.6	119.3
3	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	50,000.0	88,021.2	38,021.2	176.0
4	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-850,000.0	-820,338.2	29,661.8	96.5
5	Үл хөдлөх хөрөнгийн татвар	200,000.0	231,193.3	31,193.3	115.6
6	Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар	213,000.0	251,811.4	38,811.4	118.2
7	Улсын тэмдэгтийн хураамж	220,000.0	227,907.1	7,907.1	103.6
8	Газрын дуудлага худалдааны орлого	67,000.0	144,900.9	77,900.9	216.3
9	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	105,000.0	118,886.8	13,886.8	113.2
10	Байгалийн ургамал ашигласны төлбөр	965,614.8	1,892,175.6	926,560.8	196.0
11	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	323,435.3	376,057.3	52,622.0	116.3
12	Хувьцааны ногдол ашиг	2,711.0	4,211.5	1,500.5	155.3
13	Төсөвт газрын өөрийн орлого	73,110.0	73,878.0	768.0	101.1
14	Хүү, торгуулийн орлого	210,000.0	372,640.8	162,640.8	177.4
15	Нэр заагдаагүй бусад орлого	220,000.0	276,851.9	56,851.9	125.8
16	Хөрөнгө борлуулсаны орлого	37,000.0	42,703.5	5,703.5	115.4
ДҮН		6,875,196.8	8,431,904.6	1,556,707.8	
2016 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ТАСАРСАН ОРЛОГУУД					
№	ᠰᠡᠭᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ			
		ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	Зөрүү	Хувь
1	Бууны албан татвар	88,408.0	68,429.0	-19,979.0	77.4
2	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	45,000.0	24,546.8	-20,453.2	54.5
3	Ойн нөөц ашигласны төлбөр	383,932.0	319,718.8	-64,213.2	83.3
4	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	18,303.9	16,129.9	-2,174.0	88.1
ДҮН		535,643.9	428,824.5	-106,819.4	

Тасарсан орлогыг сумдаар авч үзвэл: 19 суманд 14 нэр төрлийн орлого 189.0 сая төгрөгөөр, Санхүү, төрийн сангийн хэлтсийн 1 нэр төрлийн буюу улсын тэмдэгтийн хураамжийн орлого 30.1 сая төгрөгөөр тасарсан боловч ОНТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар орлогын төлөвлөгөөг 1556.7 сая төгрөгөөр давуулж, 106.8 сая төгрөгөөр тасалсан байна. Тухайлбал:



- Тариат сум 4 нэр төрлийн орлогыг 10.7 сая төгрөгөөр,
- Хайрхан сум 7 нэр төрлийн орлогыг 10.1 сая төгрөгөөр,
- Хашаат сум 7 нэр төрлийн орлогыг 5.6 сая төгрөгөөр
- Цэнхэр сум 6 нэр төрлийн орлогыг 5.9 сая төгрөгөөр,
- Ихтамир сум 6 нэр төрлийн орлогыг 31.2 сая төгрөгөөр,
- Жаргалант сум 2 нэр төрлийн орлогыг 1.2 сая төгрөгөөр,
- Өгийнуур сум 8 нэр төрлийн орлогыг 7.6 сая төгрөгөөр,
- Хотонт сум 5 нэр төрлийн орлогыг 10.3 сая төгрөгөөр
- Цахир сум 4 нэр төрлийн орлогыг 2.3 сая төгрөгөөр
- Төвшрүүлэх сум 5 нэр төрлийн орлогыг 6.6 сая төгрөгөөр
- Эрдэнэбулган сум 4 нэр төрлийн орлогыг 6.9 сая төгрөгөөр
- Өндөр-Улаан сум 3 нэр төрлийн орлогыг 2.1 сая төгрөгөөр
- Чулуут сум 5 нэр төрлийн орлогыг 2.7 сая төгрөгөөр
- Эрдэнэмандал сум 7 нэр төрлийн орлогыг 16.2 сая төгрөгөөр
- Хангай сум 7 нэр төрлийн орлогыг 7.0 сая төгрөгөөр
- Батцэнгэл сум 6 нэр төрлийн орлогыг 11.9 сая төгрөгөөр
- Булган сум 6 нэр төрлийн орлогыг 32.1 сая төгрөгөөр
- СТСХ 1 нэр төрлийн орлогыг 30.1 сая төгрөгөөр тус тус орлого тасарсан байна.

Өмнөх жилийн санхүүгийн аудитаас орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх тал дээр анхаарч ажиллах талаар зөвлөмжийг хүргүүлж байсан боловч энэ жилийн төсвийн орлогын нэр төрлийн гүйцэтгэлээс харахад зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна гэж үзлээ. Өмнөх аудитаар дараах зөвлөмжийг хүргүүлж байсан.

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,277,466,000.00	2,068,134,760.00	209,331,240.00	90.81
212	ТАТААС	104,590,000.00	104,590,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,509,401,600.00	11,731,236,868.00	778,164,732.00	93.78
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,650,387,800.00	3,777,323,471.21	873,064,328.79	81.23
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,983,445,400.00	1,237,536,660.00	1,745,908,740.00	41.48
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	66,778,578,700.00	63,213,363,733.86	3,565,214,966.14	94.66
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,444,815,400.00	38,327,943,228.02	-883,127,828.02	102.36
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	37,444,815,400.00	37,246,291,259.81	198,524,140.19	99.47
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.00	1,081,651,968.21	-1,081,651,968.21	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,742,766,100.00	21,275,917,431.45	2,466,848,668.55	89.61
320001	Орон нутгийн төсвөөс	20,562,842,700.00	19,177,645,931.45	1,385,196,768.55	93.26
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,179,923,400.00	2,098,271,500.00	1,081,651,900.00	65.98
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,590,997,200.00	3,609,503,074.39	1,981,494,125.61	64.56
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,181,023,300.00	1,589,968,169.30	1,591,055,130.70	49.98
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,374,300.00	45,733,505.00	-1,359,205.00	103.06
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,365,599,600.00	1,973,801,400.09	391,798,199.91	83.44
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	994,405,182.44	-994,405,182.44	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,386,012,513.60	-1,386,012,513.60	0.00

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар **62,819.8** сая төгрөгийн гүйцэтгэл гарсны **57,804.9** сая төгрөг буюу 92.0 хувийг урсгал зардалд, **3,777.3** сая төгрөг буюу 6.0 хувийг хөрөнгийн зардалд, 1,237.5 сая төгрөг буюу 2.0 хувийг сум хөгжүүлэх сангийн зээл олголтонд зарцуулсан байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг нийт дүнд нь харьцуулбал цалингийн зардал 47.5 хувийг, ажил олгогчоос төлөх НДШ 5.3 хувийг, тогтмол зардал 7.3 хувийг, хангамж, бараа материалын зардал 1.7 хувийг, нормативт зардал 4.8 хувийг, эд хогшил урсгал засварын зардал 1.0 хувийг, томилолтын зардал 0.3 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2.1 хувийг татаас, бараа үйлчилгээний бусад зардал 3.2 хувийг, татаас, урсгал шилжүүлгийн зардал 18.8 хувийг, хөрөнгийн зардал 6.0 хувийг, 2.0 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэл төлөвлөгдсөнөөс **3,958.8** сая төгрөгөөр зарцуулагдаагүй үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн байгууллагуудын хэмнэлтээр төлөвлөрүүлсэн болон өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс гүйцэтгэл гаргаагүй нийт **613.2** сая төгрөг
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хэмнэлтээр төвлөрүүлсэн болон орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс гүйцэтгэл гараагүй нийт **207.5** сая төгрөг
- ОНХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл **625.6** сая төгрөг

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

- СХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалгүйгээс зээл олголт **1,756.5** сая төгрөгөөр дутуу санхүүжигдсан
- Халамжийг сангийн гүйцэтгэл төлөвлөгдсөнөөс **756.0** төгрөгөөр дутуу зарцуулагдсан зэргээс тус тус шалтгаалжээ.

Архангай аймгийн ТЭЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг төсөвт байгууллагын батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлээр авч үзвэл:				
				Мянган төгрөгөөр
№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сумын ЗДТГ	6,941,656.2	6,463,288.5	478,367.7
2	Аймгийн ИТХ	364,500.0	361,800.7	2,699.3
3	Аймгийн ЗДТГ	1,844,281.8	1,764,678.8	79,603.0
4	Засаг дарга	821,874.5	820,737.1	1,137.4
5	Орон нутгийн өмчийн газар	231,913.0	229,588.9	2,324.1
6	Хотын захирагчийн алба	289,733.7	287,297.7	2,436.0
7	Орон нутгийн хөгжлийн сан	3,779,561.3	3,153,966.8	625,594.5
8	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	9,905,007.4	9,149,022.5	755,984.9
9	Байгаль орчин ногоон хөгжлийн газар	832,333.2	813,029.7	19,303.5
11	Сумын ИТХурал	938,055.1	922,051.1	16,004.0
12	Санхүүгийн хяналт,аудитын алба	115,393.9	110,256.3	5,137.6
13	Ойн анги	117,165.7	111,010.9	6,154.8
14	Орон нутгийн төсвөөс /нийт/	26,181,475.8	24,186,729.1	1,994,746.70
15	Сумдын сум хөгжүүлэх сан	3,016,198.3	1,259,675.7	1,756,522.6
16	Тусгай зориулалтын шилжүүлэг	37,580,904.7	37,373,367.0	207,537.7
	НИЙТ	66,778,578.8	62,819,771.8	3,958,807.0

Зардлын данс бүртгэлтэй холбоотой Төсвийн шууд захирагчдын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлын талаар:

Зардлыг зориулалт бусаар зарцуулсан, шууд зардлаар бүртгэсэн, цалин илүү олгосон, илүү цагийн хөлс зөрүүтэй олгосон, тушаал шийдвэргүйгээр зардал гаргасан, УИХ-ын 2016 оны 09-р сарын 09-ний өдрийн 47-р тушаалын 2.в.2-д “Албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх” гэсэн заалтыг зөрчин гар утасны төлбөр төлсөн зэрэг нийт **25.3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн.

Үүнд: Ажилчдын гар утасны төлбөрийг байгууллагаас төлсөн 5.9 сая төгрөгийн, зориулалт бус зарцуулсан болон шууд зардлаар бүртгэсэн 12.3 сая төгрөгийн, цалин илүү олгосон, илүү цагийн хөлс зөрүүтэй олгосон, тушаал шийдвэргүйгээр зардал

гаргасан зэрэг 7.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага болон төлбөрийн акт тогтоож ажиллалаа.

5.7.2 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР:

Тайлант онд орон нутгийн салбарын байгууллагууд 892.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ. Үүний 59.1 хувийг орон нутгийн төсвийн байгууллагууд, 23.7 хувийг боловсрол соёлын байгууллага, 6.8 хувийг Хүүхэд гэр бүл залуучуудын газар, 1.7 хувийг Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, 8.7 хувийг ГХБХБГазар зарцуулжээ.

Салбарын ангилал	Авсан нэмэлт санхүүжилт/ мянган.төг/
Орон нутгийн төсвийн байгууллагууд	527,528.9
Боловсрол Соёл Шинжлэх ухааны сайд	211,804.7
Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайд	60,495.7
Эрүүл мэндийн сайд	15,474.2
Барилга хот байгуулалтын сайд	77,417.8
Нийт дүн	892,721.3

5.7.3 ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нь **37,444.8** сая төгрөгийн санхүүжилт, **136.1** сая төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөтэй ба гүйцэтгэлээр үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоор **126.7** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэлээр **37,373.4** сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгтээр харуулбал:

/ Мянган төгрөгөөр/

№	Салбарууд	Тусгай зориулалтын шилжүүлэг / мянган төгрөг/		Өөрийн орлого / мянган төгрөг/		Нэгдсэн тайлангаарх төлөвлөгөө /мянган төгрөг/	Нэгдсэн тайлангаар гарсан гүйцэтгэл /мянган төгрөг/	Хэмнэлт+ хэтрэлт -
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	БСШУ-ны сайд	31,465,055.4	31,300,170.4	136,089.3	127,422.4	31,601,144.7	31,427,566.73	173,578.0
2	БХБ-ын сайд	240,431.5	239,121.9	-	-	240,431.5	239,121.9	1,309.6
3	ХАХНХ-ийн сайд	167,480.6	167,478.4	-	-	167,480.6	167,478.4	2.2
4	ЭМ-ийн сайд	5,571,847.9	5,539,200.0	-	-	5,571,847.9	5,539,200.0	32,647.9
	Дүн	37,444,815.4	37,245,970.7	136,089.3	127,422.4	37,580,904.7	37,373,367.0	207,537.7

Гүйцэтгэлээр **37,373.4** сая төгрөг буюу төлөвлөгдсөн нийт зардал 99.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүний шалтгааныг тодруулбал: БХБСайд 1.3 сая төгрөг, БСШУС 167.0 сая төгрөг, ЭМС 32.6 сая төгрөг нийт 200.9 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн, мөн 6.6 сая төгрөгөөр өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүйгээс гүйцэтгэл гараагүй холбоотой байна.

5.7.4 САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн төсөл сангийн тайланд 19 сумын орон нутгийн хөгжлийн сан, 19 сумын сум хөгжүүлэх сан, 13 сумын МӨОНСан, 8 байгаль хамгаалах сан, 4 мал хамгаалах сан, өмч хувьчлалын сан, аймгийн ОНХС, орон сууцны сан, хүүхдийн төлөө сан, ХО-ын барьцаа хөрөнгө зэрэг 69 төсөл сан хамрагдлаа. Үүнээс МӨОНС-12, МХС-3, БХС-8, өмч хувьчлалын сан, орон сууцны сан, хүүхдийн төлөө сан зэрэг сангуудыг өмнөх жилийн аудитаас өгсөн зөвлөмжийг дагуу хаасан байна.

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, авлагын үлдэгдлийг харуулбал:

/мянган төгрөгөөр/

Төсөл сангийн мөнгөн хөрөнгө, авлагын үлдэгдлийн судалгаа							
№	Төсөл сангийн нэр	Мөнгөн хөрөнгө /эхний үлдэгдэл/	Мөнгөн хөрөнгө /эцсийн үлдэгдэл/	Мөнгөн хөрөнгө / зөрүү /	Авлага /эхний үлдэгдэл/	Авлага /эцсийн үлдэгдэл/	Авлага /зөрүү/
1	Орон нутгийн хөгжлийн сан /19 сум, аймаг/	362,138.1	638,263.6	276,125.5	-	-	-
2	Сум хөгжүүлэх сан /19 сум/	554,244.5	709,181.9	154,937.4	7,014,346.8	7,011,084.4	(3,262.4)
3	МӨОНС	26,637.1	-	(26,637.1)	-	-	-
4	Мал хамгаалах сан	92,491.0	64,396.4	(28,094.6)	26,546.5	4,111.9	(22,434.6)
5	Байгаль хамгаалах сан	10,317.8	-	(10,317.8)	-	-	-
6	Өмч хувьчлалын сан	-	-	-	-	-	-
7	Орон сууцны сан	1,103.5	-	(1,103.5)	-	-	-
8	Хөрөнгө оруулалтын барьцаа	314,296.2	956,990.3	642,694.1	-	-	-
9	Хүүхдийн төлөө сан	-	-	-	-	-	-
Нийт		1,361,228.2	2,368,832.2	1,007,604.0	7,040,893.3	7,015,196.3	(25,697.0)

- Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бүтцээр нь авч үзвэл: 29.9 хувийг СХС-ийн үлдэгдэл, 26.9 хувийг ОНХС, 40.4 хувийг ХО-ын барьцаа хөрөнгө, 2.8 хувийг МХС-ийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

- Төсөл сангийн авлага өмнөх оноос 25.7 сая төгрөгөөр буурсан нь төсөл сангийн шугамаар иргэдэд олгож байгаа зээлийн авлага болон МХС-ийн авлагын эргэн төлөлттэй холбоотой байна.

ОНХСангийн талаар

Аймгийн ИТХ-ийн тодотгосон тогтоолоор 2016 онд Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд авах орлогын шилжүүлэгийг **3,179.9** сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт орлого болон суурь орлогын зөрүүгээр **237.5** сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс **362.1** сая төгрөг нийт **3,779.5** сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас **3,179.9** сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрээс **237.5** сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл **362.1** сая төгрөг нийт **3,779.5** сая төгрөгийн эх үүсвэрийг зарцуулахаас сумдад **2103.3** сая төгрөгийн санхүүжилт, аймгийн ОНХС **1,402.1** сая төгрөгийг нийт **3,505.4** сая төгрөгийг олгожээ.

ОНХСангийн бодит үлдэгдэл аймгийн хэмжээнд **638.3** сая төгрөг байна. Үүний **12.3** сая төгрөг нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн, **626.0** сая төгрөг нь сумдын орон нутгийн хөгжлийн сангийн дансан дахь үлдэгдэл байна.

5.8 ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮНГИЙН ТАЛААР:

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүн 2015 оны эцэст **47,419.4** сая төгрөг байснаас **5.5** хувиар өсч **50,016.1** сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Хуримтлагдсан үр дүн	47,419,408.30	50,016,152.20	2,596,743.90
Өмнөх үеийн дүн		48,114,328.30	
Тайлант үеийн үр дүн		1,901,823.90	

ОНТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаас үзвэл 2015 оны тайлант хугацаанд 7,952.1 сая төгрөгийн үр дүнтэй гарчээ. Үүнд үйл ажиллагааны орлого өмнөх оноос 18,057.2 сая төгрөгөөр буюу 13.6 хувиар, мөн үйл ажиллагааны зардал 2,032.6 сая төгрөгөөр буюу 2.03 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /	
		2015 он	2016 он
1	Татварын орлого	7,280,848.1	8,090,443.6
2	Тусламж, санхүүжилтийн орлого	84,294,848.8	67,007,297.9

4	Татварын бус орлого	23,321,385.7	33,076,034.9
5	Үйл ажиллагааны орлогын дүн	114,897,082.7	108,173,776.4
6	Үйл ажиллагааны зардлын дүн	98,136,703.3	97,642,511.3
7	Үйл ажиллагааны бус орлогын дүн	1,240,078.5	530.0
8	Үйл ажиллагааны бус зардлын дүн	10,048,309.7	8,629,971.2
9	Үйл ажиллагааны нийт үр дүн	7,952,148.2	1,901,823.9
10	Орлогын нэг төгрөгт ногдох зардал	0.93	0.98

Дээрх хүснэгтээс үзэхэд 2015 онд 1 төгрөгийн үйл ажиллагааны орлогод ногдох зардал 0.93 төгрөг байсан бол 2016 онд 0.98 төгрөг болж өссөн нь санхүүгийн үйл ажиллагаа өмнөх оноос үр ашиг буурч байгааг харуулж байна.

Үйл ажиллагааны орлогыг бууруулсан гол орлогын нэр төрөл нь тусламж, санхүүжилтийн орлого, татварын бус орлогууд байна. Өөрөөр хэлбэл тусламж, санхүүжилтийн орлого нь өмнөх оноос 17,287.5 сая төгрөгөөр буюу 20.5 хувиар, татварын бус орлого нь 9,574.6 сая төгрөгөөр буюу 41.8 хувиар тус тус буурсантай холбоотойгоор үйл ажиллагааны үр дүн буурсан байна.

5.9 ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ТАЛААР:

5.9.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Орон нутгийн нэгтгэсэн тайлангийн ЗГ-ын капитал/орон нутгийн сан/ 2015 оны эцэст 53,600.4 сая төгрөг байсан бол тайлант онд 51,483.0 сая төгрөг болж 2,117.4 сая төгрөгөөр буурсан байна.

5.10 ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

2015 оны эцэст хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 29,397.5 сая төгрөг байсан бол тайлант онд 29,230.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оноос 166.8 сая төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь дахин үнэлгээний нэмэгдэлтэй үндсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

5.11 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

2016 оны 12-р сарын 03-ны 06 тоот Аймгийн ИТХ –ын тодотгосон тогтоолоор аймгийн авто замын сангийн зарлагын төлөвлөгөөг 223.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 223.8 сая төгрөгийг зам гүүрийн 3 ажилд зарцуулсан байна.

6.1 ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АУДИТЫН ТАЛААР:

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Үүний дагуу ОНТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд Ерөнхий боловсролын 34 сургууль, 35 Цэцэрлэг, 19 соёлын төв, аймгийн Музей, Номын сан, ХДТеатр, БТСгазар, Насан туршийн боловсролын төв, 17 сумын эрүүл мэндийн төв, 5 өрхийн эмнэлэг, , ХГБХХэлтэс, ГХБХБГазар нийт 117 байгууллагын санхүүгийн тайланг хамруулсан байна.

7.1 ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР:

2016 онд Аймгийн ТЕЗ-ийн харъяа байгууллагуудын хэмжээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан хуваарийн дагуу төсвийн шууд захирагчийн 166 / орон нутгийн-45, ЭМСалбарын-22, БСШУСалбарын-93, ГХБХБСалбарын-1, ХАХНХСалбарын-1, БОАЖСалбарын-4/ санхүүгийн тайланг аудитад хамруулах төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр орон нутгийн салбарын -25, ЭМСалбарын-17 БСШУСалбарын-30, ГХБХБСалбарын-1, ХАХНХСалбарын-1, БОАЖСалбарын-1 нийт 72 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт өгсөн байна. Төсвийн шууд захирагчдын 40 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, төсвийн шууд захирагчдын 54 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

8.1 СУМДЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР:

Аймгийн хэмжээнд Ерөнхий аудиторов баталсан хуваарийн дагуу 19 сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийх төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 19 сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн байна. Аудитаар Булган, Өлзийт сумдын төсвийн ерөнхийлөн захирагчдын нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгч, Төрийн аудитын тухай хуульд зааснаар хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.

9.1 ОРОН НУТГИЙН САН, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР:

Аймгийн төсөл сангийн тайланд аймгийн болон 19 сумын орон нутгийн хөгжлийн сан, 19 сумын сум хөгжүүлэх сан, 14 сумын МӨОНСан, 8 байгаль хамгаалах сан, 4 мал хамгаалах сан, өмч хувьчлалын сан, орон сууцны сан, хүүхдийн төлөө сан, ХО-ын барьцаа хөрөнгө зэрэг 69 төсөл санг түүвэрт хамруулан шалгасан бөгөөд санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй. Харин СХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаад зөвлөмж хүргүүлэн ажилласан. ОНХС-ийн зарцуулалтыг нийцлийн аудитаар шалгаж байгаа ба Орон нутгийн нөөц хөрөнгийн зарцуулалтыг шалгаагүй байгаа болно.

10.1 ОНӨҮГ-ЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮНГИЙН ТАЛААР:

Аймгийн хэмжээнд 4 ОНӨҮГазар аудитад хамрагдахаас Хашаат, Өндөр-Улаан, Төвшрүүлэх сумдын эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайлан нь аудитад хамрагдаагүй, Ундарга орон нутгийн өмчит ХХК нь аудитад хамрагдаж ТБОНӨХБАҮХАТухай хуулийн зүйл заалтууд болон Компаний дүрмийг зөрчсөн тендер, худалдан авах ажиллагаатай 120.0 сая төгрөгийн, орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн үедээ тус байгууллагын захирал нь орон тооны зөвлөхөөр ажиллаж 4,5,6-р саруудад 3.6 сая төгрөгийн цалин авсан, захирлын хамаарал бүхий этгээдийн хувийн компани болох Цогт өнжүүл ХХК-аас өмнөх жилд 4.7 сая төгрөгийн авлагын тооцоотой байсан ба уг авлагын тооцоог 2016 оны 12-р сард цэвэр бохир усны хоолой нийлүүлж авлагыг хаасан зэрэг 128.4 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн. Эдгээр нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байсанд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өглөө.

11.1 СУМДЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИД БОЛОН ТҮҮНИЙ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГИЙН ТАЛААР:

Архангай дахь Төрийн Аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3 дахь заалтын дагуу орон нутгийн төсвийн шууд захирагчдийн 166, сумын ТЕЗ-19, сумдын төсөл сангийн -69, ОНӨҮГ-ын -4 нийт 258 санхүүгийн тайлан аудитад хамрагдахаас 98.8% нь бүрэн хамрагдсан.

Төсвийн шууд захирагчдын 73, сумын ТЕЗ-ийн 19, ОНӨҮГ-ын -1 нийт 93 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 40 санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 122 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа. Харин Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа хувийн 3- эмийн эргэлтийн сангууд хөрөнгийн хувьд санхүүгийн тайланд нэгтгэгдэж байгаа бөгөөд аудитад хамрагдаагүй болно.

ОНТЕЗ-ийн харъяа байгууллагуудын Аудитын санал дүгнэлтийг авч үзвэл 85 санхүүгийн буюу 92.4 хувь нь “Зөрчилгүй санал дүгнэлт”, 7 санхүүгийн тайлан буюу 7.6 хувь нь “Хязгаарлалттай санал дүгнэлт” дүгнэлтийг өгч ажилласан байна. / хавсралт -1 /

Аудитаар илэрсэн зөрчлийн талаар аудитын тайлангийн дээрхи бүлгүүдэд дурьдсан бөгөөд ОНТЕЗ-ийн харъяа байгууллагуудад нийт **2,124.6** сая төгрөгийн зөрчил илэрч үүний **48.6** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **623.6** сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлж, **1,324.1** сая төгрөгийн зөрчилд цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг өгч, **128.3** сая төгрөгийн зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллалаа.

12.1 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ОНТЕЗ-ийн өмнөх жилийн СТА-аар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 66.7%-ийн биелэлттэй байна. үүнийг авч үзвэл:

№	Зөвлөмжийн агуулга	Биелэлт	Хэрэгжилтийн байдал
1	Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 1-р хавсралтын 3.10 дах заалтыг зөрчсөн 91.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.Тухайлбал: Биеийн тамир спортын газар 64.1 сая төгрөгийг, Хотын захирагчийн алба 27.7 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7-р зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн 7 байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 20.3 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчил илэрсэн.	Хэрэгжсэн	2016 онд шууд зардлаар тайлагнасан 9.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ гараагүй харин анхан шатны баримт засварласан зөрчил гарсан байна
2	Орон нутгийн төсвийн орлогын төвлөрүүлэлтийн байдал нийт дүнгээрээ 1,642.9 сая төгрөгөөр давсан сайн талтай боловч орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрөл бүр дээр бүх сумдын хувьд жигд биелэгдсэн гэж үзэхэд учир дутагдалтай байна. Төсвийн орлогы нэр төрөл бүрээр авч үзвэл 12 нэр төрлийн орлого 1,642.9 сая төгрөгөөр давж, 14 нэр төрлийн орлого 19 суманд 249.5 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрөх орон нутгийн төсвийн 8 нэр төрлийн орлого 396.0 сая төгрөгөөр тус тус тасарсан дүнтэй байна. Мөн Цэцэрлэг, Өлзийт, Хашаат сумдын орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээрээ 17.1 сая төгрөгөөр тасарсан байна.	Хэрэгжээгүй	19 суманд 14 нэр төрлийн орлого 189.0 сая төгрөгөөр тасарсан байна. Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Цэцэрлэг, Батцэнгэл сумдын орон нутгийн төсвийн орлого нийт 29.3 сая төгрөгөөр тасарсан байна.
3	ТЕЗ-ийн тайлангаар нийт 7521.1 сая төгрөгийн авлагатайгаас төсөвт байгууллагын 91.4 сая төгрөгийн, төрийн сан 46.3 сая төгрөгийн, төсөл сан 7193.5 сая төгрөгийн, ОНТӨҮГазар 189.9 сая төгрөгийн авлагатай байгаа.Үүнээс төсөвт байгууллагын 20.5 сая төгрөгийн авлага нь 7 байгууллагыг үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн олон жилийн насжилттай авлага байна. Төрийн сангийн авлага нийт 46.3 сая төгрөг байгаагаас 39.8 сая төгрөг нь 2001 онд үүссэн 14	Хэрэгжээгүй	Хэлтсийн ажлын төлөвлөгөөнд сургалтын хөтөлбөрийг тусгаж, 2015 оны эхний хагас жилд төрийн сангийн мэргэжилтнүүдэд 2 удаа, төсвийн нягтлан бодогч нарт 1 удаа сургалтыг хийсэн ба төсөвт байгууллагуудын дунд

*АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН*

	жилийн насжилттай өвс тэжээлийн авлага, 6.5 сая төгрөг нь Атрын 3-р аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон зээлийн авлага байна Төсөвт байгууллага 584.8 сая төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.Энэ нь санхүүжилт хасагдсан, мөн цэвэр бохир ус, халаалтын зардлын үнэ тариф өссөнтэй холбоотой үүссэн өр төлбөрүүд байна.		үзүүлэх сургуулийг 4 удаа хийжээ.
4	2015 оны жилийн эцсийн эд хөрөнгө бараа материалын тооллогыг хуулийн хугацаанд хийж, тооцоо бодоогүй үнэн зөв тайлагнаагүй 2650.0 сая төгрөгийн зөрчил нь 9 байгууллагын үйл ажиллагаатай холбоотой байна. Малын нас дэвшилт болон үрэгдсэн мал данснаас хасаагүйтэй холбоотой 5 байгууллагын 125.6 сая төгрөгийн зөрчил байна.	Хэрэгжсэн	Тайлант онд эд хөрөнгийн тооллого хийгдээгүй, малын нас дэвшил хийгээгүй зэрэг зөрчил илрээгүйгээс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж үзэж байна.
5	Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар тогтоолоор төсвийн гүйцэтгэлийн зарлагын төлөвлөгөөг 62299.1 сая төгрөгөөр баталсныг орон нутгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн төлөвлөгөөнд 62582.6 сая төгрөгөөр тусгаж зөрүү 283.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан байгаа нь төрийн уялдаа холбоо муу байна.	Хэрэгжсэн	Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 19 суманд Сум хөгжүүлэх сан төлөвлөгөөтэй болсон энэ нь аймгийн ИТХ-ын тогтоолд орж батлагддаггүйгээс 3016.2 сая төгрөгөөр зөрсөн байна
6	2015 оны ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 69 төсөл сан нэгтгэгдснээс СХС-19, ОНХС-20, МӨОНС-14, МХС-4, БХС-8, ЭС-1, Өмч хувьчлалын сан-1, Орон сууцны сан 1, Хөрөнгө оруулалтын барьцаа зэрэг сангууд байна.Төсвийн тухай хуулийн 18.4-д “Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж зааснаар орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг уг хуулиар зохицуулахаар заасан.Төсөв санхүүгийн харилцааг зөвхөн төсвийн тухай хууль тогтоомжоор зохицуулах хуулийн шаардлагад нийцүүлэн УИХ-аас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр МУЗЗНДНТУТХ-ийн 18-р зүйлийн 18.1.2.в “орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн сан байгуулах, уг сангийн эх үүсвэр, зориулалтыг тогтоох, сангийн хөрөнгийн зарцуулалтын журам, тайланг батлах”, 29-р зүйлийн 29.1.1-д “орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн санг бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах” гэсэн заалтуудыг хүчингүй болгон өөрчилж баталсан.Төсвийн тухай хуулиар орон нутагт зөвхөн аймаг, нийслэл болон сум, дүүргийн “орон	Хэрэгжсэн	Шаардлагагүй сангуудын үйл ажиллагааг хааж ажилласан байна

	нутгийн хөгжлийн сан” байхаар зохицуулагдсан тул 2016 оны төсвийн жилээс эхлэн орон нутаг дахь тусгай сан нэртэй бусад сангуудыг дээрх хуульд нийцүүлэн татан буулгах ажлыг зохион байгуулах, үлдэгдлийг төвлөрүүлэх шаардлагатай байна.		
	Хэрэгжсэн зөвлөмжийн тоо	4	66.7%
	Хэрэгжээгүй зөвлөмжийн тоо	2	33.3%

13.1 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Аудитын санал дүгнэлтийн үндэслэл Орон нутгийн Ерөнхийлөн Захирагчийн 2016 оны 12 сарын 31-нээр тасалбар болгон бэлтгэсэн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал үзвэрийг гаргалаа.

14.1 УЛАМЖЛАХ САНАЛ

1. Төрийн сангийн авлага нийт 46.3 сая төгрөг байгаагаас 39.8 сая төгрөг нь 2001 онд үүссэн 15 жилийн насжилттай өвс тэжээлийн авлага, 6.5 сая төгрөг нь Атрын 3-р аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон зээлийн авлага байгаа бөгөөд хоорондын тооцоо нийлсэн актгүй байна. Эдгээр авлагыг барагдуулах талаар өмнөх жилийн аудитаар зөвлөмж хүргүүлж байсан хэдий ч энэ жилийн тайланд мөн барагдаагүй, ямар байгууллага, хувь хүнээс авах нь тодорхойгүй байна. Иймд олон жилийн насжилттай, эзэн холбогдогчгүй, хоорондын тооцоо нийлсэн актгүй, төлөгдөх боломжгүй дээрх авлагыг судлан үзэж данс бүртгэлээс хасах арга хэмжээг авч ажиллахыг **Сангийн Яаманд** уламжилж байна.
2. ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 45.2, Боловсрол Соёл Шинжилэх Ухаан, Сангийн сайдын хамтарсан 560/276 тоот тушаалаар баталсан *“Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, /хоол/, дотуур байрны хүүхдийн хоол, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, коллежид суралцагчдын тэтгэлгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх зарцуулах журам”*-ыг үндэслэн сургууль, цэцэрлэгийн хоол, үдийн цай, дотуур байрны хүүхдийн хүнсний үлдэгдлийг их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөнтэй холбоотой 55.6 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоосон. Өөрөөр хэлбэл тухайн жилийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэлийг хэмнэлтэнд тооцохгүй тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлэх ёстой гэж үзсэн. Үүний нэгэн адилаар төсвийн нэгтгэсэн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдлийг авч үзвэл дараах байдал ажиглагдлаа.

Төсвийн нэгтгэсэн тайлан дахь **төсвийн байгууллагын** бараа материалын үлдэгдэлийг сүүлийн 3 жилээр харьцуулж харвал 2015 онд өмнөх оноос 544.5 сая төгрөгөөр, 2016 онд өмнөх оноос 269.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45.2 дахь заалтад нийцүүлэн авч үзвэл төсвийн жилийн батлагдсан төсвөөр эргэлтийн хөрөнгө нөөцөлсөн өөрөөр хэлбэл тухайн тайлангийн хугацаанд жинхэнэ зарлага болоогүй тул зарцуулагдаагүй гэж үзэхээр байна. Иймд хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллахад үүнээс тодорхой хэмжээний хөрөнгө нь тухайн шатны төсөвт төвлөрч дахин хуваарилалт орох, тодорхой хэмжээний төсвийн эх үүсвэр бий болох магадлалтай байна гэж үзэж байна.

Иймд энэ асуудлыг улсын хэмжээнд нэгтгэн, судлаж, Төсвийн тухай хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс Санхүү төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад уламжилан, нэгдсэн арга хэмжээ авч өгнө үү.

ХАВСРАЛТ: ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ АВСАН БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр	Хязгаарлалттай санал дүгнэлт авсан шалтгаан
1	Жаргалант сумын ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр 58.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авахдаа ТӨХ-ны зөвшөөрөл аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.4-д “... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн хороонд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн Тээвэр шатахууны зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт алдагдсан буюу жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, норм бодож хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүйтэй холбоотой 6.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн. Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдэл хангахгүй байна.
2	Хайрхан сумын ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр 1.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авахдаа ТӨХ-ны зөвшөөрөл аваагүй, 3.0 сая төгрөгийн олон жилийн насжилттай малын дутагдлаас үүссэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Тээвэр шатахууны зардлыг 2.6 сая төгрөгөөр хэтрүүлж өр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн. Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдэл хангахгүй байна
3	Жаргалант сумын Ахлах Сургууль	Хүнсний материалд бүртгэлээр тавих хяналт алдагдсан буюу няравын тайланг дутуу гаргасан, санхүүгийн тайлангийн анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй, хүнсний зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй, санхүүгийн тайлан эд хариуцагчийн тайлан зөрүүтэй зэрэг 57.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдэл хангахгүй байна.
4	Хотонт сумын Өндөр сантын Дунд Сургууль	Хүнсний материалын зарцуулалтын тайланг алдаатай бичиж материалын тайланг дутуу гаргасан, санхүүгийн тайлангийн анхан шатны баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй, үдийн цай, хүүхдийн хоолны зардлын дундаж нормативыг баримталдаггүй, хүүхдийн тоог бодитоор гаргадаггүй, хэтрэлт хэмнэлтийг тооцдоггүй зэрэгтэй холбоотой 26.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. МУЗГ-ын 2012 оны 106 тоот “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” тогтоолг зөрчсөн. Мөн Үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны санхүүжилтийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүй их хэмжээний хүнсний материал бэлтгэсэн 4.2 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрлээ. Энэ нь Боловсрол Соёл Шинжилэх Ухаан, Сангийн сайдын хамтарсан 560/276 тоот тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, хоол, дотуур байрны хүүхдийн хоол, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, коллежид

		суралцагчдын тэтгэлгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх зарцуулах журам"-ыг зөрчжээ. Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “хэмжилт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
5	Булган сумын ТЕЗ	Сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 18.0 сая төгрөгийн өртөг бүхий гудамжны гэрэлтүүлэг, 19.9 сая төгрөгийн өртөг бүхий сумын хүндэтгэлийн хаалга зэрэг нийт 37.9 сая төгрөгийн хөрөнгүүдийг Засаг даргын тамгын газрын 2016 санхүүгийн тайланд орлого авч бүртгэж тайлагнаагүй орхигдуулжээ. Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын 5.1-т “...хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр тухайн төсөвт байгууллагын тайлан балансанд бүртгэнэ ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.
6	Өлзийт сумын ТЕЗ	Сумын орлого бүх нэр төрлөөрөө буюу нийт дүнгээрээ 12.4 сая төгрөгөөр тасарсан, Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 11.9 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй зэрэг нийт 24.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Мөн өмнөх жилийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
7	Ундарга ОНӨХХК	ТБОНӨХБАҮХАТухай хуулийн зүйл заалтууд болон Компаний дүрмийг зөрчсөн тендер, худалдан авах ажиллагаатай 120.0 сая төгрөгийн, орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн үедээ тус байгууллагын захирал нь орон тооны зөвлөхөөр ажиллаж 4,5,6-р саруудад нийт нийт 3.6 сая төгрөгийн цалин авсан, тус байгууллагын захирлын хамаарал бүхий этгээдийн хувийн компани болох Цогт өнжүүл ХХК-аас өмнөх жилд 4.7 сая төгрөгийн авлагын тооцоотой байсан ба уг авлагын тооцоог 2016 оны 12-р сард цэвэр бохир усны хоолой нийлүүлж авлагыг хаасан зэрэг 128.4 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн. Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.